Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА Ч.ХИШИГДАЛАЙГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин<br>Эхний хагас жил | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО 1. ГАЗРЫН ТОСНЫ ОРДЫН АШИГЛАЛТ, ОЛБОРЛОЛТЫН ХЭМЖЭЭГ 2023 ОНД 866,666 ТОННД ХҮРГЭНЭ.** | | | | | | | |
| **ШСБ-3.3, ЗГҮАХ-3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.** | | | | | | | |
| 1.1 | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж, нөөцийг өсгөх | - | Хөрөнгө оруулалтын хэмжээ, шинээр байгуулсан БХГ-ний тоо, нөөц хэмжээ | 11 сая ам.доллар, БХГ-15, 335 мян.тонн | 15 сая ам.доллар, БХГ-2, 626 мян.тонн | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх хүрээнд 2024 онд газрын тосны хайгуулын 4, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 2, нийт 6 талбайд БХГ байгуулах эрх олгох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2024.10.23-ны өдрийн 135 дугаар тогтоолоор Төв XXXVI талбай, 136 дугаар тогтоолоор Дарьганга XXIV талбай, 137 дугаар тогтоолоор Хэрлэн-Тохой XXVIII талбай, 2024.11.13-ны өдрийн 165 дугаар тогтоолоор Гурванбаян XXX талбай, 166 дугаар тогтоолоор Борзон VII талбай, 167 дугаар тогтоолоор Ачит XXXVII талбайд БХГ байгуулахаар тус тус баталсан. Төлөвлөсөн хэмжээнээс 4 БХГ нэмэлтээр байгуулж, төлөвлөгөө давуулан биелүүлсэн үзүүлэлттэй байна. Ашиглалтыг эрчимжүүлж, нөөцийг өсгөх хүрээнд БХГ-т Галба XI талбайн Өлгийн ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны салбар хуралдаанаар 2024.01.26-ны өдөр хэлэлцүүлж, зохиогчийн хувилбараар нөөцийг хүлээн авах шийдвэр гаргуулсан. Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын "Галба XI | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талбайн нөөц бүртгэх тухай” 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар тус талбайн нөөцийг ЭБМЗ-ийн зөвлөмж, дүгнэлтийн дагуу хүлээн авсан. Тус компанийн тооцоолсон ашиглалтын баталгаат нөөц нь 1.1 сая баррель буюу 160,4 мянган тонн газрын тосны нөөцийг шинээр ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн. Монгол Улсын хэмжээнд хайгуулын ажлын үр дүнгээр 2010, 2012, 2021 онуудад газрын тосны баталгаат нөөцийг 333.79 сая тонн, ашиглалтын баталгаат нөөц 43.40 сая тонноор нөөцийн нэгдсэн санд бүртгэн авсан. Тус ашиглалтын баталгаат нөөцөөс 1996-2023 оны хооронд 11.1 сая тонн газрын тос олборлосон ба үлдэгдэл ашиглалтын баталгаат нөөц 32.0 сая тонн байна. | |
| 1.2 | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул судалгааны ажил, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлох | - | Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая ам.доллар | 11 | 15 | Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул судалгааны ажлыг нэмэгдүүлэх хүрээнд 2024 онд хайгуулын 13 гэрээлэгчийн 15 талбайд жилийн ажлын уулзалт зохион байгуулж, 10 талбайд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв батлуулсан. Тус 10 талбайд нийт 3000 тууш.км соронзон судалгаа, 610 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 50 км.кв талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, нүүрсний давхаргын метан хийн 10 цооногт 4310 тууш.м хайгуулын өрөмдлөг, 4 туршилтын хэвтээ цооног, газрын тосны хайгуулын 7 цооногт 15,480 тууш.м өрөмдөхөөр төлөвлөсөн бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээ 46.3 сая ам.долларт хүрсэн. | 100 |
| 1.3 | Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | - | Шинээр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний тоо | 15 | 2 | 2024 онд 2 БХГ байгуулахаар төлөвлөснөөс газрын тосны хайгуулын 4, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 2, нийт 6 талбайд БХГ байгуулах эрх олгох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2024.10.23-ны өдрийн 135, 136, 137, 2024.11.13-ны өдрийн 165, 166, 167 дугаар тогтоолыг тус тус батлуулсан. Газрын тосны хайгуулын 4 талбайд 8 жилийн хугацаанд нийт 108.5 сая ам.доллар, нүүрсний давхаргын метан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийн хайгуулын 2 талбайд 10 жилийн хугацаанд нийт 21 сая ам.долларын хөрөнгө оруулалт төлөвлөгдсөн байна. | |
| 1.4 | Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулах | Ашиглалт олбор-лолтын хөрөнгө оруулалт-ын хэмжээ /хувийн хэвшил/ | Газрын тосны олборлолт мян.тонн | 350.3 | 626.0 | БХГ-т Галба XI талбайн Өлгийн ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны салбар хуралдаанаар 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, зохиогчийн хувилбараар нөөцийг хүлээн авах шийдвэр гаргасан. Үүнд Баталгаат зэрэглэл (1P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 12.5 сая баррель буюу 1.8 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу ашиглалтын баталгаат нөөц нь 1.1 сая баррель буюу 160.4 мянган тонн, магадлалтай зэрэглэл (2P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 16.5 сая баррель буюу 2.4 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нөөц (P1+P2) нь 2.1 сая баррель буюу 295.2 мянган тонн, боломжтой зэрэглэл (3P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 21.5 сая баррель буюу 3.1 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нэмэх нь боломжтой нөөц нь (P1+P2+P3) нь 3.4 сая баррель буюу 490.4 мянган тонн байна. | 100 |
| 1.5 | Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх | Хөрөнгө оруулалт | Газрын тосны олборлолт, мян.тн. | 350.3 | 626.0 | Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалах ажлын хүрээнд Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд "Петрочайна Дачин Тамсаг" ХХК, БХГ-97 талбайд "Доншен газрын тос (Монгол)" ХХК-иуд олборлолтын үйл ажиллагаа тогтвортой эрхэлж байгаа бөгөөд 2024 онд тус хоёр талбайгаас нийт 3.8 сая баррель буюу 516,7 мян.тонн газрын тос олборлож, 3.7 сая баррель буюу 506,6 мян.тонн тосыг БНХАУ-д экспортолсон. Газрын тосны орлогоос улсын төсөвт 2024 онд нийт 195.7 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Газрын тосны ордын ашиглалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Дорнод аймгийн Матад сум дахь Матад XX талбайн "Цэн тогоруу" ордын олборлолтын ажлыг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эхлүүлж, нэгдүгээр цооногийг олборлолтод шилжүүлээд байна. Цэн тогоруу ордын газрын тосны нөөцийг баталгаат зэрэглэлээр 1.15 сая тонн, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137,9 мян.тонноор ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн байдаг. Тус ордоос 2024 оны туршилтын байдлаар өдөрт 200 баррель газрын тос олборлохоор төлөвлөөд байна. Монгол Улсын хэмжээнд нийт 43.40 сая тонн ашиглалтын баталгаат нөөцөөс 1996-2023 оны хооронд 11.1 сая тонн газрын тос олборлосон ба үлдэгдэл ашиглалтын баталгаат нөөц 32.0 сая тонн байна. | |
| 1.6 | Дамжуулах хоолойн инженер техникийн зураг төслийг батлуулах, трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулах | Бүтээг-дэхүүн урьд-чилан борлуу-лах гэрээ | Газрыг тусгай хэрэгцээнд авсан тухай шийдвэр | Трассыг эцэслэн тогтоосон. | Тусгай хэрэгцээнд авсан байна. | Тос дамжуулах хоолойн трассын дагуу байр зүйн зураглал, инженер геодези, хээрийн судалгааны ажлыг эхлүүлж, нарийвчилсан солбицлын цэгүүдийг тодорхойлон хоолойн трассын тэнхлэгээс тус бүр 100 метр (нийт 200 м) зурвас газарт аливаа газрын давхцалыг арилгах арга хэмжээг авсан. Дамжуулах хоолой дайран гарах Дорнод, Сүхбаатар, Дорноговь зэрэг аймагт дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан улсын тусгай хэрэгцээнд газар авахыг эдгээр аймгийн ИТХ-аар дэмжсэн шийдвэр гарсан. Хоолойн трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай БХБЯ-аас ирүүлсэн Засгийн газрын “Нууц” тогтоолын төсөлд 2023.06.27-ны өдрийн 01/..., 2023.12.26-ны өдрийн 01/... дугаартай, 2024.03.20-ны өдрийн 01/.... дугаартай албан бичгээр тус тус хариу боловсруулж хүргүүлсэн. Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг Засгийн газрын 2024.05.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. | 100 |
| 1.7 | Дамжуулах хоолойн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх | Бүтээг-дэхүүн урьд-чилан борлуу-лах гэрээ | Ажлын явц, хувиар | 30 | 70 | Бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх зорилгоор Засгийн газрын шийдвэрийн төсөл, танилцуулга боловсруулан хуралдаанаа хэлэлцүүлж, Засгийн газрын 2024.04.24-ний өдрийн 170 дугаар тогтоолоор төслийн ерөнхий гүйцэтгэгч “Норинко” компанид барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгуулах ажлыг зохион байгуулсан. 2024.12.01-ний өдрийн байдлаар хоолой цувих ажил нийт 520,2 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | км, хоолойн гагнуурын ажил нийт 515,4 км хийгдсэн бөгөөд төслийн нийт гүйцэтгэл 68 хувьтай үргэлжилж байна. | |
| 1.8 | Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах | /БНЭУ-ын 3Г-ын хөнгөлөлттэй зээл/ | Ажлын явц, хувиар | 11 | 36 | Засгийн газрын 2024.04.24-ний өдрийн 170 дугаар тогтоолоор төслийн ерөнхий гүйцэтгэгч “Мега Инженеринг” компанид барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгуулах ажлыг зохион байгуулсан. Мөн өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр ААНОАТТХуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн ба хуулийн төслийг УИХ-ын чуулганы 2024.05.31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Төслийн гүйцэтгэл тайлант хугацаанд EPC-01 багц 100 хувь дууссан бол EPC-02 багц 23.8 хувь, EPC-03 багц 17.0 хувь, EPC-04 багц 8.0 хувь, ерөнхий дүнгээр 21.2 хувийн гүйцэтгэлтэй байна. | 70 |
| 1.9 | Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх. | /БНЭУ-ын 3Г-ын хөнгөлөлттэй зээл/ | Ажлын явц, хувиар | 11 | 36 | Төслийн барилга угсралтад шаардлагатай бараа материалыг албан татвараас чөлөөлүүлэх, тоног төхөөрөмжийг гаалийн түр горимоор оруулах, багц ажлын ерөнхий гүйцэтгэгчдийн ажлын төлбөрийг шилжүүлэх тухай нийт 135 хүсэлтийг Сангийн яаманд хугацаанд нь шуурхай уламжлан хүргүүлж, шийдвэрлүүлсэн. Төслийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 2025 онд 4300 гадаад ажилчдыг ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх хүсэлтийг ГБХНХЯ-нд уламжлан хүргүүлсэн. Засгийн газрын 2024.04.24-ний өдрийн 170 дугаар тогтоолоор төслийн ерөнхий гүйцэтгэгч “Мега Инженеринг” компанид барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгуулсны дагуу холбогдох төслийн ажлууд үргэлжилж байна. | 100 |
| 1.10 | Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулах | 2,834,500 Хувийн хэвшил | Газрын тосны бүтээгдэхүүн, сая тн. | 2.2 | 2.4 | 2024 онд нийт 2.5 сая гаруй тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон. Үүнд: 90-ээс доош октантай автобензин 5,5 мян.тонн, 90-ээс дээш октантай автобензин 796,9 мян.тонн, дизель түлш 1.485,1 мян.тонн, шатдаг хий 42,2 мян.тонн, ТС-1 агаарын хөлгийн түлш 71,6 мян.тонн, бусад газрын тосны бүтээгдэхүүн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 167,9 мян.тонн байна. Өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад нийт импортын хэмжээ 382,4 мян.тонн буюу 15 хувиар өссөн бөгөөд жилийн эцсийн гүйцэтгэлээр төлөвлөсөн зорилтоос 200,0 орчим мян.тонноор давж биелэхээр байна. 2024.12.02-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд А-80 автобензин 19 хоног, Аи-92 автобензин 28 хоног, Аи-95 автобензин 40 хоног, дизель түлш 20 хоног, ТС-1 онгоцны түлш 22 хоногийн ердийн хэрэглээний үлдэгдэлтэй, хангамж нийлүүлэлт тогтвортой үргэлжилж байна. | |
| 1.11 | Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн талаар Монгол, Оросын Засгийн газар хооронд хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах | - | Хэлэлцээрийн тоо | 0 | 1 | Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд “Газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг АҮЭБ-ийн сайдын 2024.10.07-ны өдрийн 01/602 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын 2024.10.09-ний өдрийн 123 дугаар тогтоолоор батлуулсан. Тус хэлэлцээрээс гадна “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Засгийн газрын 2024.10.09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн тэмдэглэл гаргуулсан. Тус хоёр хэлэлцээрийн явцын талаар ОХУ-ын холбогдох талд мэдээлэл уламжлан хүргүүлэх тухай хүсэлтийг газрын даргын 2024.11.14-ний өдрийн 07/1011 дүгээр албан бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн. Тус хэлэлцээрүүдийг байгуулснаар Монгол Улс, ОХУ-ын газрын тосны салбарын хамтын ажиллагаа гүнзгийрч, ОХУ-аас худалдан авах газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт тогтвортой үргэлжлэх боломж бүрдэх юм. | 100 |
| 1.12 | Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. | Хувийн хэвшил | Евро-5 стандартын шатахууны хэрэглээ, хувиар. | 22 | 25 | 2024 онд нийт 2.5 сая гаруй тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 2.0 сая тонн байна. Үүнээс К5 /Евро-5/ ангиллын шатахуун 292,285 тонн буюу нийт шатахууны импортын 14 хувийг эзэлж байна. Тус газрын зүгээс Улаанбаатар хотын агаарын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл /3-р үе шат/-ийн хүрээнд УУХҮЯ, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, БОАЖЯ, Япон улсын Жайка хамтын ажиллагааны байгууллагын хамтарсан хорооны ажлын хэсэгт ажиллаж Евро-5 шатахууны импорт, хэрэглээний талаар танилцуулга, мэдээллээр тогтмол ханган ажилласан. Мөн Евро-5 стандартын автобензинийн импорт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр БНХАУ-ын “Петрочайна интернэйшнл” компаниас импортлох бүтээгдэхүүний захиалгыг БНХАУ-ын төмөр замын тухайн сарын хуваарьт оруулж, баталгаажуулах тухай хүсэлтийг ГХЯ-аар уламжлуулан БНХАУ-ын ЭСЯ-нд УУХҮ-ийн сайдын 2024.01.24-ний өдрийн 01/179 тоот, ТНБД-ын 2024.01.23-ны өдрийн 03/165, 2024.01.24-ний өдрийн 01/179, 2024.05.02-ны өдрийн 03/987 тоот, байгууллагын хэрэгцээний Евро-5 стандартын автобензинийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлийг “Эрдэнэс монгол”, “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэс Оюутолгой”, “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” зэрэг байгууллагуудад УУХҮ-ийн сайдын 2024.01.29-ний өдрийн 01/239 тоот, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид УУХҮ-ийн сайдын 2024.01.29-ний өдрийн 01/240 дүгээр албан бичгээр тус тус хүсэлт хүргүүлсэн. Мөн ГХЯ-аар уламжлуулан ОХУ-ын “Роснефть” НХН-т Монгол Улсад нийлүүлэх Евро-5 ангиллын шатахууны хэмжээг нэмэгдүүлэх талаарх хүсэлтийг ТНБД-ын 2024.10.29-ний өдрийн 03/830 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| 1.13 | “Газрын тосны бүтээгдэхүүний чанарын стандарт, хяналтын тогтолцоог сайжруулж, хангамжийг тогтворжуулах” ажлын хүрээнд газрын тосны | - | Гүйцэтгэсэн ажлын тоо | 1 | Жилд 1 удаа | Газрын тосны бүтээгдэхүүний хяналтын тогтолцоог сайжруулах чиглэлээр Шатахуун түгээх станцуудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, холбогдох танилцуулгын хамт хуучин нэрээр УУХҮ-ийн сайдын 2024.04.19-ний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүтээгдэхүүний чанар, стандартад хяналт тавих ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах. | | | | | өдрийн 01/891 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын 2024.05.01-ний өдрийн 189 дүгээр тогтоолоор батлуулсан. Үүний дагуу "MNS 4628:2013 Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага" стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, газрын даргын 2024.05.13-ны өдрийн 08/1068 дугаар албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлж, стандартад нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулсан. Мөн "Шингэрүүлсэн нүүрс устөрөгчийн хий ашигладаг байгууламжийн аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг шинэчлэн батлуулахтай холбогдуулан Салбарын хяналтын газартай хамтран санал боловсруулж, газрын даргын 2024.03.28-ны өдрийн 08/694 дүгээр албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлж, дүрмийн төсөлд нэмэлт өөрчлөлт тусгуулсан. Үүнээс гадна Монгол Улс жилдээ 50 орчим мянган тонн хийн түлш хэрэглэж байгаа бөгөөд хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр шатдаг хийн түлшний хадгалалт, түгээлт, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааг хангах эрх зүйн орчныг сайжруулах, хяналтын тогтолцоо, чадавхыг бэхжүүлэх, хэрэглэгчдэд аюулгүй ажиллагааны талаар сурталчлан таниулах шаардлага үүссээр байна. Иймд энэ чиглэлээр хамтран ажиллах талаар УУХҮЯ болон БНСУ-ын Корей Gas Safety Corporation болон Лаб газ компанитай хамтран ажиллах саналыг ТНБД-ын 2024.04.15-ны өдрийн 03/892 дугаар албан бичгээр БНСУ-ын KIS байгууллагад, 03/897 дугаар албан бичгээр Койка болон БНСУ-ын ЭСЯ-нд мөн ТНБД-ын 2024.04.22-ны өдрийн 03/899 дүгээр албан бичгээр ГХЯ-нд тус тус санал хүргүүлсэн. Хийн түлшний хяналт, аюулгүй ажиллагаа, хууль эрх зүйн орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх төслийг боловсруулан БНСУ-ын Корей Gas Safety Corporation байгууллагад хүргүүлж, хамтын ажиллагааг эхлүүлсэн. АМГТГ-ын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэстэй хамтран Улаанбаатар хот дахь 5 ААН-ийн 5 агуулах, 8 ШТС-ын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах ажлыг зохион байгуулж, оролцсон. | |
| 1.14 | Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах. | - | Компанийн нөөцийн хэмжээ, мян.тн. | 132.7 | 146.5 | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, Засгийн газрын 2012 оны 126 дугаар тогтоолд тус тус заасны дагуу жил бүр импортлогч аж ахуйн нэгжүүдийн заавал бүрдүүлэх газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн хэмжээг Засгийн газрын тогтоолоор батлуулдаг. Үүний дагуу 2025 оны газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн хэмжээг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга боловсруулж, АҮЭБ-ийн сайдын 2024.09.19-ний өдрийн 01/465 дугаар албан бичгээр яамдаас санал авч нэгтгэн АҮЭБ-ийн сайдын 2024.10.10-ны өдрийн 01/633 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын 2024.10.23-ны өдрийн 134 дүгээр тогтоолоор батлуулсан. Тогтоолын дагуу 2025 онд нийт 64 ААН 179,880 тонн газрын тосны бүтээгдэхүүн буюу Монгол Улсын түлш, шатахууны хэрэглээний 30 хоногийн нөөцтэй тэнцэхүйц хэмжээний нөөцийг заавал бүрдүүлэхээр тогтсон. Нөөцийн тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг газрын даргын 2024.11.13-ны өдрийн 08/1000 дугаар албан бичгээр АМГТГ-т хүргүүлсэн. | 100 |
| 1.15 | Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын үлдэгдэл нөөцийн мэдээг тогтмол авах ажлыг цахимжуулах асуудлыг зохион байгуулах | - | Цахимжсан-1 Цахимжаагүй-0 | 0 | 1 | Холбогдох мэдээллийг цахимжуулах чиглэлийг АМГТГ-т 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/201 албан бичгээр хүргүүлсэн. Цахим систем хөгжүүлэлтийг гүйцэтгэх ажлын төсөв АМГТГ-ын 2024 оны төсөвт батлагдсан. АМГТГ нь агуулах, ШТС-ын үлдэгдэл, нөөцийн мэдээг "Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн мэдээллийн систем"-ээр дамжуулан 100 хувь цахимаар хүлээн авч байна. | 100 |
| **Зорилго 2. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2020 онд 84.7 хувь байгааг 2023 онд 85 хувьд хүргэнэ.** | | | | | | | |
| Зорилт 2. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож сайжруулна | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх. | - | ЗГ-т хүргүүлсэн эсэх 0-хүргүүлээгүй 1-хүргүүлсэн | 2005 оны Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль | 1 | УУХҮ-ийн сайдын 2023.08.30-ны өдрийн А/282 дугаар тушаалаар байгуулагдсан Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, судалгааг үндэслэн хуулийн төсөлд тусган дахин боловсруулсан. Хуулийн төсөл боловсруулах хүрээнд БНСУ-ын Газрын тосны бүтээгдэхүүний худалдааны хууль болон бүтээгдэхүүний чанарт хяналт тавих тогтолцооны талаар мэдээлэл авч санал солилцох хамтарсан уулзалтыг УУХҮЯ дээр зохион байгуулсан. Мөн хуулийн төсөлд салбарын мэргэжлийн холбоод болон БНСУ-ын “КПетро” байгууллагаас санал авсан. Ашигт малтмалын тухай хуулийг УИХ-аар хэлэлцүүлсний дараа тус хуулийн төслийг өргөн барихаар тогтсон тул холбогдох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 100 |
| **Зорилго 3. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэж, яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2020 онд 84.7 хувь байгааг 2023 онд 85 хувьд хүргэнэ.** | | | | | | | |
| Зорилт 3. Газрын тосны салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна. | | | | | | | |
| 3.1 | Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавих. | - | Засгийн газрын 2021.10.06-ны өдрийн 311 дугаар тогтоол, мян.тн. | 193.5 | 132.7 | Засгийн газрын 2023 оны 385 дугаар тогтоолоор нийт 53 аж ахуйн нэгж 146,500 тонн газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэхээр тогтоосон. Тогтоолд хамрагдсан импортлогч ААН тус бүртэй АМГТГ 2024 оны нэгдүгээр сард нөөц хадгалах гэрээ байгуулсан бөгөөд нөөц бүрдүүлэлтэд АМГТГ-тай хамтран тухай бүр хяналт тавьж ажилласан. Нөөцийг тогтворжуулах, хангамжийг тасралтгүй үргэлжлүүлэх чиглэлээр ЭЗХЯ-нд 2024.01.19-ний 01/156 тоот, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдад 2024.01.24-ний 01/179 тоот, импортлогч аж ахуйн нэгжүүдэд 2024.01.29-ний 01/238 тоот, ЗТХЯ-нд 2024.02.01-ний 01/266 тоот, АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдад 2024.03.22-ны 02/630 тоот, “Роснефть Монголия” ХХК-нд 2024.05.01-ний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 08/980 тоот, Сангийн яаманд ТНБД-ын 2024.07.22-ны 03/01 тоот, ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдад 2024.08.15-ны 03/177 тоот, ОХУ-ын “Роснефть” НХН-т 2024.10.29-ний 03/830 тоот албан бичгүүдийг тус тус хүргүүлсэн. 2024.12.02-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд А-80 автобензин 19 хоног, Аи-92 автобензин 28 хоног, Аи-95 автобензин 40 хоног, дизель түлш 20 хоног, ТС-1 онгоцны түлш 22 хоногийн ердийн хэрэглээний ердийн хэрэглээтэй тэнцэх буюу нийт 112,595 тонн түлш, шатахууны үлдэгдэл, нөөцтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад түлш, шатахууны нийт үлдэгдэл, нөөцийн хэмжээ 41,050 тонн буюу 36 хувиар нэмэгдсэн. | |
| 3.2 | Газрын тосны салбарын мэргэшсэн, зөвлөх инженерүүдийн зэрэг олгох зөвлөлийг хуралдуулах, сургалтыг зохион байгуулах. | - | Хэрэгжилт % | 0 | 100 | “Газрын тосны салбарын мэргэшсэн, зөвлөх инженерүүдийн зэрэг олгох зөвлөл”-ийн хуралдааныг нийт 2 удаа зохион байгуулсан. Салбарын мэргэшсэн, зөвлөх инженерийн баримтлах “Ёс зүйн дүрэм”-ийг УУХҮ-ийн сайдын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/46 дугаар тушаалаар, сургалтын хөтөлбөр болон шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг А/45 дугаар тушаалаар тус тус батлуулж, сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 25-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад нийт 15 мэргэшсэн инженер, 8 зөвлөх инженер хамрагдсан. | 100 |
| **Зорилт 4. Геологи, уул уурхай хүнд үйлдвэр, газрын тосны салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ.** | | | | | | | |
| 4.1 | Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Зөвшөөрлийн хуультай нийцүүлэн цахим системд өөрчлөлт хийх | - | Хуульд нийцүүлэх | Цахим системд шилжсэн 100% | 100% | Газрын тосны хайгуул, ашиглалт болон газрын тос боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Зөвшөөрлийн хуультай нийцүүлэн цахим системд холбох ажлыг зохион байгуулж, www.license.mn системд 100 хувь шилжүүлсэн. | 100 |
| 4.2 | Газрын тосны салбарын хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, | - | Цахим системд шийдвэрлэ-сэн хүсэлтийн тоо | 135 | 140 | Шатахуун, шатдаг хийн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг 100 хувь цахим системээр хүлээн авч шуурхай шийдвэрлүүлсэн бөгөөд www.license.mn цахим системд нийт 220 хүсэлт хүлээн авсан. Үүнээс баримт бичгийн бүрдэлт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөнгөн шуурхай шийдвэрлэх | | | | | хуулийн шаардлага хангасан давхардсан тоогоор нийт 114 ААН-д тусгай зөвшөөрөл шинээр олгох, 36 ААН-ийн зөвшөөрлийн хугацаа сунгах тухай сайдын 65 удаагийн тушаал боловсруулж, батлуулан тусгай зөвшөөрлийн цахим гэрчилгээг олгох ажлыг зохион байгуулсан. Гааль татвар, мэдээлэл технологийн төвтэй хамтран тусгай зөвшөөрлийн баримт бичгийн бүрдүүлэлт болон улсын тэмдэгтийн хураамжтай холбоотой нийт 8 удаагийн өөрчлөлтийг www.license.mn цахим системд оруулсан. 2024 оны эхний 11 сарын байдлаар импортлох 164, бөөний худалдаа эрхлэх 186, жижиглэнгийн худалдаа эрхлэх 181 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Бүх төрлийн шатахууны худалдаа эрхлэх зөвшөөрөл бүхий 267 ААН, шатдаг хийн 40 ААН байна. Тусгай зөвшөөрлийн төлбөрөөс улсын төсөвт 2022 онд 1.4 тэрбум, 2023 онд 3.4 тэрбум төвлөрүүлсэн бол 2024 оны эхний 11 сарын байдлаар нийт 2.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. | |
| 4.3 | “2024 оныг Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд салбарын бүсчлэл болон тухайн бүсэд хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрүүдийн байршлын саналыг нэгтгэж талуудын оролцоог хангасан хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнг ЭЗХЯ-нд хүргүүлэх. | - | Мэдээлэл боловсруулах хэлэлцүүлэг зохион байгуулж үр дүнг ЭЗХЯ-нд хүргүүлсэн эсэх<br>1-тийм<br>0-үгүй | 1 | 1 | “2024 оныг Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарлах тухай” Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд салбарын бүсчлэл болон тухайн бүсэд хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрүүдийн байршлын саналыг нэгтгэж, талуудын оролцоог хангасан “Газрын тосны салбар” хэлэлцүүлгийг 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Мөн ЭЗХЯ-аас зохион байгуулсан бүсчилсэн хөгжлийн нэгдсэн хэлэлцүүлэгт 2024 оны 02 сарын 01-ний өдрөөс 02-ны өдрүүдэд оролцсон. Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт 2024.02.22 болон 2024.03.01, 2024.04.03-ны өдрүүдэд ажиллаж, газрын тосны салбарын асуудлаар санал оруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 5. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа 2019 онд 47.5 хоног байгааг 2023 онд 25 хоногт хүргэнэ.** | | | | | | | |
| Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | | | | | | | |
| 5.1 | Газар, хэлтсийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх. | - | Хуулийн хугацаанд Хэрэгжүүлээ-гүй 0, хэрэгжүүлсэн 1 | 0 | 1 | Газар, хэлтсийн 2024 оны төлөвлөгөөг нэгтгэн байгууллагын нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулсан. Хэлтсийн үйл ажиллагааны сар бүрийн тайланг нэгтгэн хугацаанд нь ТЗУГ-т тухай бүр хүргүүлсэн. | 100 |
| 5.2 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | - | Хуулийн хугацаанд Хэрэгжүүлээ-гүй 0, хэрэгжүүлсэн 1 | 0 | 1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хэлтсийн чиг үүрэгт хамаарах ажлын хүрээнд сар бүр нэгтгэн гаргаж, хугацаанд нь ТЗУГ-т цахимаар хүргүүлсэн. | 100 |
| 5.3 | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | - | Хуулийн хугацаанд Хэрэгжүүлээ-гүй 0, хэрэгжүүлсэн 1 | 0 | 1 | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг газар, хэлтсийн чиг үүрэгт хамаарах асуудлаар тухай бүр нэгтгэн гаргаж хугацаанд нь ТЗУГ-т хүргүүлсэн. | 100 |
| 5.4 | 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | - | Хуулийн хугацаанд Хэрэгжүүлээ-гүй 0, хэрэгжүүлсэн 1 | 0 | 1 | Тухайн бүр нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн. | - |
| 5.5 | Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | - | Хуулийн хугацаанд Хэрэгжүүлээ-гүй 0, хэрэгжүүлсэн 1 | 0 | 1 | Тухайн бүр нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн | - |
| 5.6 | Алсын хараа 2050-ын хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | - | Хуулийн хугацаанд Хэрэгжүүлээ-гүй 0, хэрэгжүүлсэн 1 | 0 | 1 | Тухайн бүр нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.7 | Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | - | Хуулийн хугацаанд Хэрэгжүүлээгүй 0, хэрэгжүүлсэн 1 | 0 | 1 | Тухайн бүр нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн | - |
| 5.8 | Шинэ сэргэлийн бодлогын хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | - | Хуулийн хугацаанд Хэрэгжүүлээгүй 0, хэрэгжүүлсэн 1 | 0 | 1 | ШСБ-д тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг ЭЗХЯ-нд тухай бүр хугацаанд хүргүүлсэн. | 100 |
| 5.9 | УУХҮЯ-ны стратеги төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | - | Хуулийн хугацаанд Хэрэгжүүлээгүй 0, хэрэгжүүлсэн 1 | 0 | 1 | Тухайн бүр нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн | - |
| 5.10 | Сарын ажлын тайлан нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | - | Хуулийн хугацаанд Хэрэгжүүлээгүй 0, хэрэгжүүлсэн 1 | 0 | 1 | Газар, хэлтсийн сар бүрийн ажлын тайланг нэгтгэн тухай бүр хугацаанд нь ТЗУГ-т хүргүүлсэн. | 100 |
| 5.11 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг хүргүүлэх арга хэмжээ авах. | - | Шийдвэрлэлт-ийн хувь 0-нэмэгдээгүй 1-нэмэгдсэн | 70% | 80% | Тайлангийн хугацаанд газар, хэлтсийн чиг үүрэгт хамаарах асуудлын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн нийт 349 албан бичиг, санал, хүсэлт хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу хүргүүлж, холбогдох байгууллагад уламжилсан. Үүнд: Ирсэн албан бичиг 818 байна. Эхний хагас жилийн байдлаар ирсэн өргөдөл гомдол байхгүй. Газар, хэлтсийн 264181, 261861 дугаар утсанд газрын тос хайх, ашиглах тусгай зөвшөөрөл болон салбарын үйл ажиллагааны талаар, мөн газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл, хангамж, үнэ, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар ирсэн нийт хүсэлт, санал, шүүмж, тодруулгад тухай бүр хариу өгч ажилласан. | 100 |
| 5.12 | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавруудын | Сайдын багцийн | Холбогдох журмын дагуу хэрэгжилтийг | Бичиг хэргийн | 92% | Газар, хэлтсийн албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн стандарт, зааврын хэрэгжилтийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллах. | холбогдох зардал | хангуулсан эсэх | шийдвэр-лэлт 91 % | | хангах үйл ажиллагаанд талаар тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажилласан. | |

**МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ:**

| Д/д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхлэх, дуусах огноо |
|---|---|---|---|---|
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 Байгууллагын зүгээс болон бусад төрийн ба төрийн бус байгууллагуудаас зохион байгуулах салбарын чиглэлийн цахим сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан байна. | АҮЭБЯ, Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан "Ёс зүй" сэдэв сургалтад хамрагдсан. Мөн ТАЗ-өөс долоо хоног тутам зохион байгуулж буй "7:4:10" сургалтад тухай бүр цахимаар оролцсон. | 2024.01.01-2024.12.30 |

*Төлөвлөгөөг үнэлсэн:*

***Төсвийн шууд захирагч***

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ........ /С.ЖАВХЛАНБААТАР/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг*

ATA14031 9129294 9034120060

2024.12.20

*(огноо)*

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:*

***Нэгжийн дарга***

ЖНЧДОГ дарга ........ 2024.12.09

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

........

*(огноо)*

*Тайлагнасан:*

***Нэгжийн дарга***

ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА ........ /Ч.ХИШИГДАЛАЙ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2024.12.09.

*(огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ХЭЛТЭСИЙН ШИНЖЭЭЧ ПҮРЭВДОРЖИЙН ХҮРЭЛХҮҮГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2024 онд 626000 тоннд хүргэнэ.** | | | | | | | |
| **ШСБ-3.3, ЗГҮАХ-3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөх. | Хөрөнгө оруулалтын хэмжээ, шинээр байгуулсан БХГ-ний тоо, нэмэгдсэн нөөц, олборлолтын хэмжээ | 11 сая ам.доллар, 15 БХГ, 335 мян. тонн | 7 сая ам.доллар хөрөнгө оруулалт | **Монгол Улсын хэмжээнд Газрын тосны Баталгаат нөөц:** Хайгуулын ажлын үр дүнгээр 2010, 2012, 2021 онуудад газрын тосны баталгаат нөөцийг **333.79 сая тонн** гэж бүртгэсэн.<br>**Ашиглалтын баталгаат нөөц: 43.40 сая тонн**-оор нөөцийн нэгдсэн санд бүртгэн авсан.<br>Монгол Улсын хэмжээнд **43.40 сая тонн** ашиглалтын баталгаат нөөцөөс 1996-2023 оны хооронд **11.1 сая тонн** газрын тос олборлосон ба үлдэгдэл ашиглалтын | 2024.01.01 - 2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталгаат нөөц **32.0 сая тонн** байна.<br><br>Засгийн газрын 2009 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 147 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Галба XI талбайд Зон хэн юу тиан ХХК-тай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-г баталсан. Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийг 2009 оны 07 дугаар сарын 23-ны өдөр авсан.<br>Зон хэн юу тиан ХХК нь 2009-2019 онд Галба XI талбайн Өлгий хотгорт нийт 1316 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 358 км$^2$ талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, хайгуул, үнэлгээний 14 цооног өрөмдөж, нийт 20628 тууш метр өрөмдлөг хийсэн. 8 цооногоос авсан чөмөг чулуун дээжинд лабораторийн шинжилгээ хийж, 6 цооногт туршилт, үнэлгээ хийсэн. БХГ-т Галба XI талбайн Өлгийн ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны салбар хуралдаанаар 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, зохиогчийн хувилбараар нөөцийг хүлээн авах шийдвэр гаргасан. Тус компанийн тооцоолсон ашиглалтын баталгаат нөөц нь 1,1 сая баррель буюу 160,4 мянган тонн газрын тосны нөөцийг шинээр ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн.<br>Газрын тосны ашиглалтын 4 талбайд 2024 онд нийт 58,5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн ба компани тус бүрээр авч үзвэл Петрочайна дачин тамсаг ХХК Тсон-Уул, Тамсагийн орд газарт 50,86 сая ам.доллар, Доншен газрын тос /Монгол/ ХХК Зүүнбаян-Цагаан элсний ордод 6,2 сая ам.доллар, Петро Матад ХХК Цэнтогоруу ордод 1,43 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 1.2.<br>Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулна. | ЭБМЗ-ийн газрын тосны салбар хуралдааны тоо | 4 талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. | Нөөц нэмэгдсэн байна. | БХГ-т Галба XI талбайн Өлгийн ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны салбар хуралдаанаар 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, зохиогчийн хувилбараар нөөцийг хүлээн авах шийдвэр гаргасан. Үүнд Баталгаат зэрэглэл (1P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 12.5 сая баррель буюу 1.8 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу ашиглалтын баталгаат нөөц нь 1.1 сая баррель буюу 160.4 мянган тонн, Магадлалтай зэрэглэл (2P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 16.5 сая баррель буюу 2.4 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нөөц (P1+P2) нь 2.1 сая баррель буюу 295.2 мянган тонн, Боломжтой зэрэглэл (3P)-ээр байрандаа анх байгаа | 2024.01.01<br>-<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 21.5 сая баррель буюу 3.1 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нэмэх нь боломжтой нөөц нь (P1+P2+P3) нь 3.4 сая баррель буюу 490.4 мянган тонн болно. | | |
| | Арга хэмжээ 1.3. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх. | Газрын тосны олборлолт, мян.тн. | 657 мян.тн | **626 мян.тн** | Монгол Улсын хэмжээнд **43.40 сая тонн** ашиглалтын баталгаат нөөцөөс 1996-2023 оны хооронд **11.1 сая тонн** газрын тос олборлосон ба үлдэгдэл ашиглалтын баталгаат нөөц **32.0 сая тонн** байна.<br><br>2024 онд 4 850 000 баррель буюу 659202 тонн газрын тос олборлож экспортлохоос 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт **4192205** баррель буюу **562582** тонн газрын тос олборлож, **4088523** баррель буюу **555653** тонн газрын тосыг БНХАУ-д экспортлоод байна. | 2024.01.01 - 2024.12.31 | 83 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Газрын тосны ашиглалтын Матад XX талбайн Цэн тогоруу ордын газрын тосны олборлолтын ажлыг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр эхлүүлсэн. | | |
| **Зорилт 2. Газрын тосны салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| 3. | Арга хэмжээ 1.4. МУ-ын ЗГ-ын 2023 оны 481 дүгээр "2024 оныг Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарлах тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд салбарын бүсчлэл болон тухайн бүсэд хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрүүдийн байршлын саналыг нэгтгэж талуудын оролцоог хангасан хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнг ЭЗХЯ-нд хүргүүлэх. | - | Мэдээлэл боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулж үр дүнг ЭЗХЯ-нд хүргүүлсэн эсэх 1-тийм 0-үгүй | Санал хүргүүлсэн байх | МУ-ын ЗГ-ын 2023 оны 481 дүгээр "2024 оныг Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарлах тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Газрын тосны салбартай холбоотой бүсчлэл болон тухайн бүсэд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн талаарх холбогдох мэдээлэл, саналыг нэгтгэж СХОГ-т хүргүүлсэн. | 2024.01.01 - 2024.12.31 | 100 |
| **Зорилт 3. Геологи, уул уурхай хүнд үйлдвэр, газрын тосны салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ.** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Зөвшөөрлийн хуультай нийцүүлэн цахим системд нэвтрүүлнэ. | Нэвтрүүлсэн эсэх | Бодлогын даалгаврыг боловсруулж Цахим хэлтэст хүргүүлсэн | | Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Зөвшөөрлийн хуультай нийцүүлэн цахим системд шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/25 | 2024.01.01 - 2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж систем хөгжүүлэлтийн явцад гүйцэтгэгч газартай хамтран ажилласан ба шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгч 2024 оны 04 дүгээр сарын 24-нд системийг туршисан болно. Газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл олгох асуудал цахимд шилжсэн болно. | | |
| **Зорилт 4. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээг сайжруулна.** | | | | | | | |
| | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | | | | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг Газрын тосны бодлогын газрын хэмжээнд нэгтгэн гаргаж тухай бүр ТЗУГ-т хүргүүлэн ажилласан. | 2024.01.01 - 2024.12.31 | 100 |
| 3. | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг хүргүүлнэ | | | | 2024 оны 12 дугаар сарын 03-ний байдлаар 69 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хариуцах ажлын хүрээнд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, холбогдох шийдвэр болон хариуг хүргүүлэн ажилласан. | 2024.01.01 - 2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, зааврuудын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллах. | | | | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, зааврuудын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллаж байна | 2024.01.01 - 2024.12.31 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. УИХ-ын АБГББХорооны тогтоолын хэрэгжилтийг гаргаж хүргүүлэх | Тогтоолын хэрэгжилт гаргасан байх | - | ЗГ, УИХ-ын байнгын хороонд хүргүүлэх | Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн “Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашигийг нэмэгдүүлэх тухай” 3 дугаар тогтоолын хэрэгжилтийг дахин шинэчлэн гаргау 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 03/42 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. АБГББХорооны хуралдаанд танилцуулсан болно. | 2024.01.01 - 2024.12.31 | 100 |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. “Газрын тосны салбарын үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга | Хэлэлцүүлэг зохион байгуулах | - | Хэлэлцүүлэгээс санал зөвлөмж | Газрын тосны салбарын өнөөгийн байдал цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар | 2024.01.01 - 2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээ" сэдэвт хэлэлцүүлгийн салбарын ахмадын зөвлөлттэй хамтран зохион байгуулах | | | боловсруулах | хэлэлцүүлгийг салбарын ахмадын зөвлөлттэй хамтран 2024 оны 5 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулсан. Нийт 19 ахмад оролцож санал зөвлөмж өгсөн. Газрын тосны салбарын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг ахмадын хорооноос Засгийн газарт хүргүүлэхээр тогтсон. | | |
| 3 | Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлын хүрээнд гадаадаас авах ажиллах хүчний Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгах асуудлыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад уламжлан үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. | Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл болон хугацаа сунгах | - | Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл болон хугацаа сунгах асуудлыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байна | Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан 410 гадаад мэргэжилтний хөдөлмөр эрхлэх хугацааг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгах, шинээр 2025 онд Монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүсч буй 891 гадаад мэргэжилтэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэхийг хүссэн албан тоотыг ХНХЯ болон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2023,11,20-ны 03/1080 тоотоор хүргүүлсэн. | 2024.01.01 - 2024.12.31 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
